

“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр

дугаар 01

Дархан –Уул аймаг

Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 заалт, Дархан Нэхий Хувьцаат компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 заалтыг тус тус удирдлага болгон Дархан Нэхий ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, ТУЗ-ээс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр гаргасан 2025 оны 03 дугаар сарын 29- ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын 02 тоот шийдвэрийн нэг дэхь заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дархан Нэхий Хувьцаат компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Э. БАТСАЙХАН

Дархан Нэхий Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлын 2025 оны 3 дугаар сарын 29-ний
өдрийн хурлын 01 тоот тогтоолын хавсралт № 01



Дархан нэхий ХК-ийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн дүгнэлт

1. Бүтэц, зохион байгуулалтын талаар:

- 1.1. Тайлант хугацаанд Дархан нэхий ХК-ийн үйл ажиллагаа явуулж байсан 9 охин компаниас байсан цөөхөн орон тоотой жижиг компаниудын үйл ажиллагааг түр нэгтгэж, удирдлагын тогтмол орон тоог багасгах зорилгоор оёдол, гутлын Нэхий гармент, Як трейд, Як ланд 3 компанийг 1 удирдлагад, боловсруулахын 2 компанийг 1, Нэхий Агр ХХК-ийн үйл ажиллагааг зогсоож үйл ажиллагааг Нэхий трейд ХХК-д нэгтгэн нэг удирдлагад оруулж ажилласанаар тотмолоор цалин авч байсан орон тоо 30 шахам хүнээр цомхотгогдож, гүйцэтгэлээр цалинжиж байсан ажилтнуудын цалингийн дундаж өссөн сайн үзүүлэлттэй байна.
- 1.2. 20024 онд энэ зохион байгуулалтаар Дархан нэхий ХК-ийн 7 охин компаниуд ТУЗ-өөр батлагдсан төсөв, орон тоо, бүтцийн дагуу үйл ажиллагаа явуулсан. Үүнээс 2 охин компани төлөвлөгөөт зорилгоо ханган биелүүлсэн бол бусад үйлдвэрлэлийн чиглэлийн компаниуд тавьсан зорилтоо бүрэн ханган биелүүлж чадсангүй, сэргэлт удаан байна. Компаниудын хэмжээнд байнгын орон тоон дээр нийт 319 ажилтан ажиллаж, оргил ачааллын үед түр ажилтан татаж ажиллуулсан нь зардал хэмнэх, хэмнэсэн цалингийн зардлыг үндсэн ажилтнуудын цалинг өсгөх бодлого барьж ирсэн нь сайшаалтай байна.
- 1.3. Үүнээс үйлдвэрлэлийн чиглэлийн охин компаниуд нь 2024 онд 280 ажилтантай үйл ажиллагаа явуулна гэж төлөвлөснөөс 249 ажилтантайгаар ажиллаж, дундаж цалин 2,547,949 төгрөг болж өмнөх онтой харьцуулахад орон тоо 18%-буурч, дундаж цалин 27%-р өссөн дүнтэй байна. Удирдлагын цалингийн дундаж өмнөх жилээс буурсан байгаа нь 2024 онд тогтмолоор биш үйлдвэрлэлийн гүйцэтгэлтэй шууд холбоотой гэрээ байгуулж ажилласаны үр дүн юм.
- 1.4. Үйлчилгээний Гранд як ХХК 72 ажилтан ажиллахаас 58 орон тоотой ажиллаж дундаж цалин 1584992 төгрөг байна.

2. Үндсэн үйл ажиллагааны чиглэл:

- 2.1. 2024 онд компаниудын үндсэн үйл ажиллагаанд нэмэлт өөрчлөлт ороогүй бөгөөд ТУЗ-ээс өгсөн чиглэлийн дагуу үйлдвэрлэлийг зөвхөн байгаа орон тоондоо тулгуурлан явуулах, бүтээмжийг нэмэх, үйлдвэрлэлийн компаниудын хувьд бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийж, зах зээлийн эрэлт судалгааг харгалзан бүтээгдэхүүн бүрийн үр ашиг, өртөг зардлыг тооцож, алдагдсан зах зээлээ авахыг гол чиглэл болгон өгсөн учир үйлдвэрлэл өнгөрсөн онтой харьцуулбал төдийлөн өсөөгүй, харин бүтээмж нэмэгдсэн сайн талтай.
- 2.2. Үйлдвэрлэлийн чиглэлийн компаниуд үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 74,7%, борлуулалтын төлөвлөгөөг, 72,9%, зардлын төсвийн гүйцэтгэл 76,1%, ашгийн

төлөвлөгөөг -74% биелүүлсэн дүнтэй байна. Ашгийн төлөвлөгөө дутуу биелэсэн нь 810 саятөгрөгийн найдваргүй авлага, зардлын буруу бичилтийг залруулах, ашгиас хасах бичилтүүд хийсэнтэй болон суурь бүтээгдэхүүн болох арьс ширний үнийг 21% бууруулсантай холбоотой голчлон гарчээ.

2.3. Гэхдээ компанийн хэмжээнд орлого өмнөх оноос 3 % өссөн, зардал 2 % өссөн, ашиг 24 % өссөн дүнтэй байна. Үүнээс үйлдвэрлэлийн чиглэлийн компаниудын зардал 4% буурсан нь сайн үзүүлэлт юм. Харин үйлчилгээний чиглэлийн компаниудын орлого 43%, зардал 34%, ашиг 54% өмнөх онтой харьцуулбал тус тус өсжээ.

2.4. Үйлдвэрлэлийн чиглэлийн компаниудын сэргэлт удаан байгаа дараах үндсэн хүчин зүйл, шалтгаануудыг тогтоож, дүгнэлт хийн засаж залруулах арга хэмжээ авч байгаа нь зүйтэй байна. Үүнд:

2.4.1. Боловсон хүчний дутагдалд орсон учраас төлөвлөгөөт ажлын гүйцэтгэл хангагдахгүй болсон. Үүрэгжээгүй, гүйцэтгэлийн үр дүнгээр цалин авдаг тогтолцооноос гүйцэт салж чадахгүй. Үүрэгт ажлаа цаг хугацаанд нь дуусгаж цалин хөлс тооцуулна гэсэн ойлголт сул, цаг ашигдалт байхгүй. Цаг бүртгүүлээд цалин авах сонирхолтой. Боловсон хүчний чадавхи сул. Ажлаа мэддэг хүн байхгүй болсон. Энэ байдлыг засахын тулд ажлыг багаар гүйцэтгэдэг, гүйцэтгэлээр цалинжих тогтолцоог мөрдөж эхэлсэн нь үр дүнгээ өгч эхэлсэн.

2.4.2. Санхүүгийн хувьд хүндрэлд орж өрийн дарамтууд үүссэн. Үйлдвэрлэлийн тоо хөөсөн, чанар хяналтын тогтолцоо орхигдсон, өр төлбөрөө цаг хугацаанд төлөөгүй хуримтлуулж өрийн дарамт үүссэн байсныг залруулж хуучин өр төлбөрүүдийг барагдуулах ажлыг зохион байгуулж иржсэн байна.

2.4.3. Хуучин барааны үлдэгдэл ихтэй. Хэрэглэгч, зах зээлийн судалгаагүй борлохгүй, загвар мод хоцрогдсон бараанууд үйлдвэрлэж зардлаа өсгөсөн. Бараа бүтээгдэхүүний хөгжүүлэлт хийж эрэлтэнд нийцсэн бараа үйлдвэрлээгүй. Өртөг өндөр учраас зах зээл, хэрэглэгчээ алдсан байсан. Үүнийг засаж өртгийн тооцоог нарийвчлан гаргаж бүтээгдэхүүний үнийг зах зээлийн түвшингээс доогуур татаж хэрэглэгчээ татах бодлого барьсан.

2.4.4. Хөрөнгө оруулалт, хөрөнгийн бодлого алдагдсныг өөрчилж шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэл рүү хандуулж, ноосны хаягдлаа бүрэн ашиглах, ширний хаягдал өөдөс, зоргодсыг ашиглан шинэ бүтээгдэхүүн гаргах чиглэлд анхаарч төсөл тооцоо, судалгаа гаргаж ажилласан байна.

2.5. Хэдийгээр дээр дурдагдсан бодит шалтгаан байгаа боловч, үүнээс ч аюултай үндэсний хэмээх үйлдвэрлэлийг сүйрүүлэх үндсэн шалтгаан нь үйлдвэрлэл явуулах тутам өрөнд орох нөхцөл байдал төр засгийн бодлоготой холбоотой яалт ч үгүй үүсжээ. Үүнд:

2.5.1. Гуравдагч орны бараа хямд бараа бүтээгдэхүүн гаднаас хяналтгүй, татваргүй ихээр орж ирж, НӨАТ-гүй хямд зарагдах болсон нь дотоодын үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг бууруулжээ. Дотоод зах зээлийг хамгаалж, ижил төстэй импортын бүтээгдэхүүн дээр гаалийн татварыг нэмэхгүй бол цаашид үйлдвэрлэл явагдах нөхцөл байхгүй болжээ.

2.5.2. Нэг ажилтанд очих орлогоос 44%-ийн татвар, шимтгэл авч байгаа нь ажилтнуудын гарт олгох мөнгөн дүнг бууруулж байгаа нь ажиллах хүчин НДШ, ХАОАТ төлдөг аж ахуйн нэгжүүдэд ажиллах сонирхолгүй болгожээ.

2.5.3. Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх зардлын 40 шахам хувийг эзээлдэг банкны зээлийн өндөр хүү, төрийн монопол компаниудын ус, уур, дулаан, цахилгааны үнийн өсөлт,

санхүүгийн аудит, эрчим хүчний аудит, эрсдлийн үнэлгээ, хөдөлмөр хамгаалын болон элдэв төлбөрт сургалтууд, сэргээгдэх эрчим хүч, цэвэр агаар сангийн татвар гэх мэтийн элдэв төрлийн албан бус татвар хураамжийг ил далд авдаг болсон бусад паразит бүтцийг тэжээх тогтолцоо үүсгэж зардлыг нэмэгдүүлэх болсон нь цаашид үндэсний үйлдвэрлэгч нарын бүтээгдэхүүний үнэ буурч, өрсөлдөх чадвар нэмэгдэх, санхүүгийн байдал сайжрах боломжийг олгохгүй болжээ.

- 2.6. Дээрх үндсэн нөхцөл байдлыг харгалзан компаниудын бүтцийг өөрчлөлтийг хийх, бараа бүтээгдэхүүний хөгжүүлэлт хийх, хөрөнгийн болон санхүүгийн бүртгэл шинэчлэлтийн ажил хийгдэж байгаа нь цаашдаа компанийн үйл ажиллагаанд зарчмын эргэлт гарах урдич нөхцлийн эхлэлийг тавьжээ.
- 2.7. Мөн компанийн ирээдүйд гол ашиг орлого авчрах ногоон хөрөнгө оруулалт болох шахмал шир, хаягдал ноосны үйлдвэр, гутлын автомат үллагаа, тэлээ, улавчны үйлдвэр зэрэг хөрөнгө оруулалтыг 3-5 жил царцаасан байсныг хөдөлгөөнд оруулж, үйлдвэрлэлийн зардлыг бууруулах системтэй ажлын эхлэлийг тавьсан он жил болжээ гэж дүгнэж байна.

3. Хөрөнгийн талаар:

- 3.1. Эздийн өмч 60 тэрбумаас 66 тэрбум болж 9,92% өсжээ. Эргэлтийн бус хөрөнгө 47% эзлэж, хөрөнгийн өгөөж дөнгөж 1 хувь орчим байгаа сайжруулах шаардлагатай бөгөөд компанид ашиглалтгүй эргэлтийн бус 1,5 тэрбум орчим төгрөгийн хөрөнгө, хуучин бараа бүтээгдэхүүн 12 тэрбум зэрэг үнэ цэнэ тогтмол буурч буй хөрөнгүүдийг яаралтай хямдруулан зарж борлуулан идэвхтэй актив болгоход анхаарч ажилласан.
- 3.2. Өнгөрсөн жил 12 тэрбум шахам бараа материалыг 8 удаагийн тушаал шийдвэрээр 30-70% хямдруулан зарж борлуулан 5 тэрбум шахуу төгрөгийн орлого олсон нь хангалтгүй байна.
- 3.3. Мөн ашиглалтгүй хөрөнгүүдийн тооллого хийж зарж борлуулан эргэлтэд оруулах ажил зохион байгуулж ажилласнаар 22,34 сая төгрөгийн хөрөнгө материал зарж борлуулжээ.
- 3.4. Тайлант хугацаанд нийт 1,902 тэрбум хөрөнгө оруулалт, 462,44 сая төгрөгийн барилгын засвар үйлчилгээ хийж хөрөнгө сайжруулах ажил хийгдсэн байна. 50 гаруй жил ашиглагдсан барилга байгууламж дорвитой их засвар шаардлагатай болсон нь цаашид энэ чиглэлд анхаарч хөрөнгө гаргах шаардлагатай нь харагдаж байна.

4. Өр төлбөр:

5. 9,1 тэрбумаас 7,8 тэрбум болж 1,3 тэрбумаар буурсан. Урт хугацаат өр төлбөр 4,1 тэрбумаас 1,5 тэрбум болж 2,6 тэрбумаар тус тус буурсан нь санхүүгийн өрийн дарамт багсаж байгаа сайн талтай байна.
6. Зээл 4,7 тэрбумаас 1,37 тэрбум болтлоо буурсан.
7. Өр төлбөрийн дийлэнх хувийг татварын өр 5,58 тэрбумаас 5,69 тэрбум болж өссөн бөгөөд энэ хугацаанд 6,8 тэрбум төгрөгийн татвар шинээр нэмэгдэж 6,69 тэрбум төгрөгийн татвар төлсөн нь компани дөнгөж тайлант хугацаанд үүссэн татварын өрөө л төлсөн байдалтай байна.
8. Цаашид компанийн ашиг орлого нэмэгдэж, зардал буурахын хирээр үрсгал өрөөтөлөх санхүүгийн чадвар нэмэгдэх боломжтой.

9. Компанийн удирдах ажилтнуудад олгосон шагнал урамшуулал:

- 9.1. Үйлчилгээний Гранд як ХХК, санхүү, лизингийн Дэвжих нэхий ББСБ –уудын удирдлагатай хийсэн үр дүнгийн гэрээг дүгнэж ТУЗ-ийн тогтоолоо төгрөгийн шагнал урамшуулал олгосон. Бусад компанийн удирдлагууд үр дүнгийн шагнал урамшуулал аваагүй.
- 9.2. 2024 онд Дэвжих нэхий ББСБ-ийн удирдлагын гэрээний дагуу ажил дүгнэж 63,588 сая төгрөгийн урамшуулал, Гранд як ХХК-ийн ажлыг дүгнэж 184,368 сая төгрөгийн урамшуулал

олгосон. Үүнээс удирдлагад Дэвжих нэхий ББСБ 42,1 сая, Гранд як ХХК удирдлагад 107,4 сая төгрөг ноогдож бусад нь ажилтнуудын 13-р сарын цалин, шагнал урамшуулалд зарцуулагджээ.

10. Цаашид анхаарч ажиллах зүйлс:

- 10.1. Ялангуяа толгой компани болох Дархан нэхий ХК-ийн зүгээс санхүүгийн хяналт тавих, үйл ажиллагааны гүйцэтгэл дүгнэж хариуцлага тооцох, ажилтнуудыг хариуцлагжуулах, үүрэгжүүлэх, үр дүнг тооцох ажил хангалтгүй явагдаж ирлээ. Цаашдаа хяналтын фүнхц бүхий энэ завсрын ерөнхий удирдлагын үйл ажиллагааы санхүү хяналтыүүргийг ТУЗ-н аудитийн хороонд, гүйцэтгэх удирдлагуудын ажлын гүйцэтгэл дүгнэх үүргийг ТУЗ-ийн НДХороонд шилжүүлэлэн ТУЗ-өөс охин компаниудтай шууд холбоос үүсгэж ажиллах нь илүү үр дүнтэй болно гэж тооцож байна .
- 10.2. ТУЗ-ийн аудитын хороо энэ хугацаанд санхүү хяналтын үүргээ биелүүлээгүй орхигдуулснаас санхүүгийн дотоод хяналт, шалгалтийн ажил орхигдсон байгаад анхаарч ТУЗ-д мэргэжлийн үр чадвартай хүмүүсийг татан оролцуулах, хяналтыг тогтмолжуулах шаардлагатай.
- 10.3. Үр ашиг багатай зардал ихтэй компанийн зарим нэг уламжлалт бүтээгдэхүүн үйлчилгээнээс зоригтой салж, шинэчлэлтийг гүнзгийрүүлэх шаардлага байсаар байна.

“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр

дугаар 02

Дархан –Уул аймаг

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг сонгож, батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7, 77.1, 77.3, 77.4 заалтууд, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.23, мөн 7.10 заалтыг удирдлага болгон 2025 оын 03-р сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дархан Нэхий Хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгосугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг доорхи бүрэлдэхүүнээр шинэчлэн сонгож, баталсугай.

Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр:

Эрдэнэдалай овогтой Батсайхан
Равжаа овогтой Сүмбэнхүү
Батсайхан овогтой Мягмар-Өлзий
Баасан овогтой Гэрэлмаа
Ганхуяг овогтой Ган-Очир нарыг,

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр:

Тогоо овогтой Дансран
Мягмардорж овогтой Ганзориг
Лувсандорж овогтой Гүнчин
Ринчин овогтой Бямбадорж

3. Хууль тогтоомж, компанийн дүрэм, засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүний талаар олон нийтэд мэдээлж, шинээр сонгогдсон гишүүдийн талаарх мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Х.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Э. БАТСАЙХАН

“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр

дугаар 03

Дархан –Уул аймаг

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийн цалин, урамшуулал,
үйл ажиллагааны төсвийг батлах тухай


Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 заалт, Дархан Нэхий Хувьцаат компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7 заалт, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оын 03-р сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 тоот шийдвэрийн гурав дахь заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дархан Нэхий Хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2025 оны цалин, урамшуулал, үйл ажиллагааны зардлын төсвийг хавсралтаар баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсөвт зардлыг санхүүжүүлэхийг ДНХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Гэрэлмаа/-д зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Э. БАТСАЙХАН



Дархан Нэхий ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны төсөв.

№	ЗАРДАЛ	2023		2024		2024Г/2024Г		2025	2025Г/2	2025Г/2
		Төсөв /төг/	Гүйцэтгэл /төг/	Төсөв 2024 /төг/	Гүйцэтгэл 2024 /төг/	Зөрүү / %		Төсөв /төг/	024Г	024Г
1	ХЭХ-ын зар мэдээнд	420,000	420,000	460,000	400,000	-60,000	87%	400,000	1.00	0.87
2	Хувьцааны тархалтын судалгаа авах төлбөр	527,000	527,800	580,000	529,700	-50,300	91%	529,700	1.00	0.91
3	Хөрөнгийн бирж үйлчилгээний хөлс	2,551,700	2,800,000	2,800,000	2,500,000	-300,000	89%	2,500,000	1.00	0.89
4	ХЭЭХ, ТУЗ-ийн хурлын болон бизнес арга хэмжээний зардал	3,600,000	2,540,980	3,600,000	2,312,507	-1,287,493	64%	3,600,000	1.56	1.00
1.	Хурлын зардлын дүн	7,098,700	6,288,780	7,440,000	5,742,207	-1,697,793	77%	7,029,700	0.94	0.94
	Интернет, утасны зардал	660,000	1,083,239	660,000	548,593	-111,407	83%	660,000	1.20	1.00
	Бичиг, хэргийн зардал	295,000	243,200	282,000	240,280	-41,720	85%	282,000	1.17	1.00
	Халаалт, цахилгааны зардал	821,455	821,455	-	-	0	0%	-	#DIV/0!	#DIV/0!
	Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоо	455,491	868,752	868,752	868,752	0	100%	868,752	1.00	1.00
	Хоолны зардал	875,000	646,455	1,925,000	633,500	-1,291,500	33%	1,925,000	3.04	1.00
	Цалингийн зардал	108,984,600	79,944,406	96,661,920	55,878,895	-40,783,025	58%	96,661,920	1.73	1.00
	Сургалтын зардал	32,425,000	2,800,000	-	-	0	0%	1,050,000	#DIV/0!	#DIV/0!
2.	Бусад зардлын дүн	144,516,546	86,407,507	100,397,672	58,170,020	-42,227,652	58%	101,447,672	1.74	1.01
	ЗАРДЛЫН ДҮН	151,615,246	92,696,287	107,837,672	77,995,024	-58,918,959	72%	108,477,372	1.39	1.01
НИЙТ ТӨСӨВ /2025/								108,477,372		

“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр

дугаар 04

Дархан –Уул аймаг

Тогтоолын шийдвэрийг баталгаажуулах
тухай

Дархан нэхий ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2025 оын 03-р сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 тоот шийдвэрийн дөрөв, тав дахь заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дархан нэхий ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 02 сарын 14-ны өдрийн 25/05 тоот тогтоолын 2024 оны “Ногдол ашиг хуваарилах тухай” шийдвэрийг дэмжиж баталсугай.
2. Мөн Дархан нэхий ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 сарын 26-ны өдрийн 24/46 тоот тогтоолын толгой компанийн хувьцаанаас охин компаниуд зөвшөөрсөн хэмжээгээр эзэмших “Компанийн хувьцаа нэмж авах тухай” шийдвэрийг дэмжиж баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Э. БАТСАЙХАН